



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 8/92

Мандалговь

Г Салбар комисс шинэчлэн байгуулах тухай Т

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1, 42.1.1, Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн "Дүрэм батлах тухай" 200 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймгийн салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Дарга: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд: Нэгдсэн эмнэлэгийн мэдрэлийн эмч
Нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн эмч
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн
Боловсрол, соёл, урлагийн газрын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Салбар хорооны үйл ажиллагааг бэхжүүлэн, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг шинаэ шатанд гарган үр дүнтэй ажиллахыг салбар комисс /Ц.Эрдэнэсүрэн/-д үүрэг болгосугай.

Гурав. Салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн газрын дарга /Г.Хишигдаваа/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/370, 2017 оны А/88 дугаар захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.



020000274